



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 22 -ны өдөр

Дугаар А/341

Эрдэнэт

**Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд  
бэлтгэх багийг шинэчлэн томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 22.1, 22.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам батлах тухай” А/503 дугаар тушаал, 2019 оны “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах багийг нэгдүгээр хавсралтаар, багийн чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагууд нь “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-г батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллахыг байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-даалгасугай.

4. Уг тушаал гарсантай холбогдуулан ЭМГ-ын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ


Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны  
04 дүгээр сарын 22-ний өдрийн 1/34 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

### МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД БЭЛТГЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Багийн ахлагч: - Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал,  
магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Эмнэлгийн оношилгоо, эмчилгээ технологи цус цусан  
бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтэн
  - Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан  
мэргэжилтэн
  - Эмийн зохистой хэрэглээ, чанар аюулгүй байдал хариуцсан  
мэргэжилтэн
  - Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
  - Мэдээлэл технологи цахим эрүүл мэнд, сүлжээ хариуцсан  
мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны  
04 дүгээр сарын 22-ний өдрийн АБЧ дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



### БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

- 1.1 Баг нь эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үүрэгтэй ажиллах бөгөөд магадлан итгэмжлэлд бэлтгэх, хүсэлт гаргасан байгууллагыг баримт бичгийн бүрдүүлэлтэд зөвлөгөө өгөх, хүлээж авах
- 1.2 Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажлын албанд тайлагнах
- 1.3 Эрүүл мэндийн байгууллагад хийгдэж буй магадлан итгэмжлэлийн үнэлгээнд оролцох, үнэлгээгээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
- 1.4 Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх
- 1.5 Шинээр магадлан итгэмжлэлд орох хүсэлт гаргасан байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын байранд хяналт үнэлгээг хийх
- 1.6 Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх
- 1.7 Магадлан итгэмжлэлүүлэхээр хүсэлт гаргасан байгууллагуудыг [Health.acc.hdc.gov.mn](http://Health.acc.hdc.gov.mn) онлайн програмд бүртгэх, Эрүүл мэндийн газар [backend.acc.hdc.gov.mn](http://backend.acc.hdc.gov.mn) онлайн програмаар магадлан итгэмжлэлийн бүрдүүлсэн материалыг хянаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажлын албанд илгээж, магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулах